

БАТЛАВ
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Р.ОТГОНЖАРГАЛ

2024 оны 05 дугаар сарын 01-ны өдөр

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГЭРЭЭТ ХАРУУЛ
ХАМГААЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү техникийн тодорхойлолтод Гаалийн ерөнхий газрын харьяа Хяналтын нэгдсэн төв, Гаалийн төв лабораторийн онцгой байгууламжийг хамгаалах техникийн тодорхойлолтыг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь энэхүү техникийн тодорхойлолтод нийцсэн харуул хамгаалалтын үйлчилгээг үзүүлнэ.

Дараах бичиг баримтуудыг дагалдуулж ирүүлнэ. Үүнд:

- Монгол улсын хүчинтэй бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Цагдаагийн ерөнхий газрын хүчинтэй бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар

3. ХАРУУЛЫН АЖИЛТНУУДЫН ТОО, АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Байршил объект	2024 он (хүн/сар)							2025 он (хүн/сар)				
		VI	VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	V
1	Хяналтын нэгдсэн төв	3	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
2	Гаалийн төв лаборатори	3	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
3	Өдрийн цагаар	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
	ДҮН	7	7	7	7	7	7	7	7	7	7	7	7

Барилгын 2 объектод 24 цагаар хамгаална.

4. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- Харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд нь 5-аас доошгүй жил харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулсан туршлагатай байх.
- Хуваарийн дагуу ажиллах мэргэжлийн хүний нөөц, тусгай техник, тоног төхөөрөмжийн хүчин чадалтай байх.
- Харуул хамгаалалтын ажилтан нь ижил загварын, өнгө үзэмжтэй дүрэмт хувцас, тухайн байгууллагын онцлогийг тусгасан ялгах тэмдэгтэй байх.

- Байгууллагын үйл ажиллагааны хэвийн, аюулгүй нөхцлийг хангах зорилгоор ажилтан, албан хаагч, объект, автомашин, техник хэрэгслийг 24 цагийн хамгаалалтаар ханган, хамгаалалтын бие бүрэлдэхүүнийг зохион байгуулж ажиллах, хяналт тавих.
- Хамгаалж буй объектыг өдөрт 2-оос доошгүй удаа эргэж хяналт тавьж ажилладаг байх.
- Харуул хамгаалалттай холбогдсон асуудлаар хамгаалж буй нэгжийн удирдлагуудаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх.
- Хамгаалж буй объектод эрсдэл учирсан тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд шуурхай мэдэгдэж, арга хэмжээ авах системийг бүрдүүлсэн байх.
- Хамгаалалт, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт, гомдол шаардлага болон илэрсэн зөрчлийг цаг тухайд нь байгууллагын хариуцсан удирдлагад, хөндлөнгийн хууль бус үйлдлийн шинжтэй зөрчил илэрсэн үед цагдаагийн байгууллагад мэдээллийг цаг алдалгүй шуурхай мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах.
- Үйл ажиллагаатай нь холбогдуулан онцгой байдал, цагдаагийн байгууллагаас эрх зүйн хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлэх.
- Хамгаалалтад авах объект, түүний зааг хязгаар, орон зайг зураглалаар тодорхойлон хүлээн авч хяналт тавьж ажиллах.
- Харуулуудыг ажил хүлээн авсныг баталгаажуулж, тэмдэглэл хөтлөн хяналт тавьдаг байх.
- Захиалагч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон харуул хамгаалалтын журмыг хамтран хэлэлцэн баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгох.
- Харуул хамгаалалтын хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор сард 1-ээс доошгүй удаа харуулын бие бүрэлдэхүүнийг сэлгэн ажиллуулж байх.
- Захиалагч талын байгууллагын нууцыг чанд хадгалах.
- Хамгаалалтын ажилтнуудын ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйтай холбоотой бүх асуудлыг бие даан хариуцах.
- Хамгаалалтын объект бүрд харуулын илтгэлийн дэвтрийг бэлтгэх, уг дэвтрийн хуудас бүрийг дугаарлан тэмдэг дарж баталгаажуулах, хөтөлж дууссан дэвтрийг захиалагчид хүлээлгэн өгөх.
- Объектэд нэвтрэх хүмүүсийн бичиг баримт бүртгэх, (шаардлагатай тохиолдолд металл илрүүлэгч багажаар шалгаж) зөрчил илрэх тохиолдолд үр дүнг харуулын илтгэлийн дэвтэрт бичиг гаалийн байгууллагын хариуцсан нэгжийн удирдлагад тогтмол танилцуулах.

Хамгаалж байгаа объектоос эд хөрөнгө алдагдсан, хамгаалалтын ажилтны сэрэмжгүй байдлаас хохирол учирсан тохиолдолд хамгаалалтын компани хариуцлага хүлээж, хохирлыг төлж барагдуулна.

5. ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЖИЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Тогтвор суурьшилтай ажиллах.
- Элдэв муу зуршилгүй, архи хэрэглэдэггүй байх.
- Мэргэжлийн болон мэргэшлийн шаардлага хангасан байх.
- Ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөхүйц өвчин, эмгэг, муу зуршилгүй байх.
- Хамгаалж буй объектод зөвшөөрөлгүй гаднаас хүн нэвтрүүлэхгүй байхыг онцгой анхаарах.

- Хяналт тавих, тодорхой бус нөхцөл байдалд ажиллах, санал бодлоо илэрхийлэх, үнэн зөв дүгнэх, найдвартай, сэтгэл хөдлөлөө хянах, нэгдэж ажиллах, аюулгүй ажиллагааны менежмент, мэргэжил, ажлаа тайлагнах ур чадвартай байх.


6. ХҮЛЭЭН АВАХ

Үйлчлэгч нь ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлт нийцэхээ баталсан баримт бичиг, дүрэм журам болон холбогдох материалуудыг ирүүлнэ.

ГЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр хүлээн авсанд тооцно.

ТАНИЛЦСАН :

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ХОСБАЯР

САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ДОЛГОРСҮРЭН


ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Л.ОЧГЭРЭЛ

АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНГЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:

АЖ АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ АХЛАХ НЯ-БО-
ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



А.БОЛОР-ЭРДЭНЭ